

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|---|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх. | | | | | | |
| 1.1. | Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулна. 9.3.19. | - | Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 43 | 47 | “Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-гийн программ хангамжийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлсэн боловч программ хангамж нь ашиглалтын шаардлага хангахгүй тул шинэчлэх зорилгоор шаардагдах хөрөнгийг нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн. Мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлтэй болох зорилгоор нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газруудад 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/04/520 дугаартай албан бичиг хүргүүлж, судалгааг нэгтгэсэн. Энэ оны байдлаар нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт 1394 авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдэж, үүнээс 971 иргэн, 423 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын дагуу тохирлын баталгаанд заавал хамруулах, тохирлын үнэлгээг “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалт, MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг хангасан Нийслэлийн нутаг дэвсгэрт 2025 оны жилийн эцсийн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.2. | Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын хүрээнд зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлнэ. 9.3.21, НХТ 2025-106, НХТЖҮЧ-9.21.2 | - | Чиглэлийн тоо | 15 | 20 | Байдлаар автомашины засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт 18 иргэн, 42 аж ахуйн нэгж, байгууллагын 358 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэн ангилал тогтоосон. Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Yutong bus" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын евро-5 дизель хөдөлгүүртэй, их багтаамжийн 10 автобусаар парк шинэчлэлт хийж, Багахангай дүүргийн чиглэлд 1, Багануур дүүргийн чиглэлд 2, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд 7 автобусыг тус тус үйлчилгээнд гаргасан. Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжаар БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус, 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын dealгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулсан. Тус их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 15 автобусыг нийтийн тээврийн М:1 "5 шар - Офицеруудын ордон", Ч:28 "Сэлх-7 Буудал-Ард кино театр", Ч:42 "Сүлжмэл - Нарны гүүр - Зайсан" Ч:57 "Улаанчулуут -Их наран - МУИС" чиглэлүүдэд үйлчилгээнд гарган ажиллаж байна. | 85 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|--|---------------|--------------------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.3. | Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Зорчигч тээврийн терминал байгуулах боломжит байршлыг судлан танилцуулна. 9.3.22 | - | Зорчигч тээврийн терминал байгуулах боломжит байршлын судалгааны тоо | 1 | 1 | -Улаанбаатар хотоос зүүн аймаг, дүүрэг рүү чиглэх зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргээмжтэй хүргэхэд 2025 оноос MNS 6300: 2011 стандартын В ангилал стандартад нийцсэн өдөрт 5000 хүртэл хүнд үйлчлэх хүчин чадалтай зорчигч болон дотоодын ачаа тээврийн цэгийг байгуулахаар төслийн ажил эхлүүлэх гэж байгаа мэдээллийг Тэнгэр ХХК-иас ирүүлсэн. Уг ажил нь хотын алслагдсан Багануур, Багахангай дүүргийн иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжид зэрэг нөлөө үзүүлэхээр байгаа тул төслийг дэмжиж Хот байгуулалт хотын стандартын газарт 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/02/1022 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. -Тус газраас Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/618 дугаар захирамжаар байгуулагдсан Нийтийн тээврийн эцсийн зогсоолыг иж бүрэн тохижуулах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтийн шийдэл боловсруулах, хөрөнгө оруулалтын судалгааг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарын ажлын нөхцөлийг сайжруулах зорилгоор эцсийн зогсоолуудын ариун цэврийн өрөөний судалгааг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагаас авч нэгтгэсэн. Ажлын хэсэгт эхний ээлжит 25 эцсийн зогсоолын байршилд капсул байршуулах тооцооллыг гарган Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. | 100 |
| 1.4. | Сургуулийн зориулсан хүүхдэд тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. 9.3.23. | - | Сургуулийн автобус үйлчилж буй | Нийт сургуули | Нийт сургуулийн 18 хувьд | 2024-2025 оны хичээлийн жилд 83 сургуулийн 69 чиглэлд хүүхдийн 69 автобусаар 1,5 сая сурагч тээвэрлэсэн байна. 2025 оны 10 дугаар сарын | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.5. | Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ. 9.3.25. | 1 | Судалгааны тоо | - | 1 | байдалаар 82 сургуулийн 66 чиглэлд сургуулийн хүүхдийн 66 автобусаар 31,541 рейс гүйцэтгэж 1,0 сая сурагч тээвэрлэсэн байна. Сургуулийн хүүхдийн автобусны үйлчилгээнд ажилласан 5 ОНӨААТҮГ болон нийслэлийн 3 дүүргээс ирүүлсэн мэдээг замын хуудастай тулган нэгтгэж сар бүрийн рейсийн гүйцэтгэлийн мэдээг гарган ажиллаж байна. Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжтэй хамтран ажиллахаар 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр "Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний гэрээг байгуулсан. Зөвлөх үйлчилгээний багаас "Эхлэлийн уулзалт"-ыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Дэлхийн банк болон төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран тус газарт зохион байгуулсан. Тус газар болон Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжээс "Эхлэлийн тайлан"-д тусгах саналыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүргүүлж, 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулж, зөвлөх үйлчилгээний хүрээнд холбогдох баримт бичиг, мэдээллийг хэрхэн авах, цаашид зөвлөх багийн гадаад мэргэжилтнүүд Монгол Улсад ажиллахад хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон. Уг зөвлөх үйлчилгээний мэргэжилтэн Монгол Улсад ирж ажиллахтай холбогдуулан Монгол талын зөвлөхтэй 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж одоогийн ашиглаж буй тээврийн удирдлагын төвийн үйл ажиллагааг танилцуулсан. Нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх | 90 |

| Д/А | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2. | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго: Нийтийн эрэлт, хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн автомашинны хэрэглээг багасгаж, нийтийн тээвэр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5. | | | | | Үйлчилгээний Техник, эдийн засгийн үндэслэлийн дундын тайланг эцэслэх ажил 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 95 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. | |
| 2.1. | Зорилт 2. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолтой чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлнэ. НЗДҮАХ 1.5.2 | | | | | Улаанбаатар хотын 8 байршилд шинээр 8 дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан. Үүнд: -Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорын эцсийн автобусны зогсоолын тохижилтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. -Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Туул тосгоны шинэ эцэс, хуучин эцэст дулаан автобусны зогсоолыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байнгын ашиглалтад хүлээн авсан. | |
| 2.1.1 | Нийтийн тээврийн хэрэгслийн замналын дагуух саравчтай болон дулаан зогсоолуудын тоог нэмэгдүүлэх; НХТЖҮЧ-9.22.3. | - | Зогсоолын тоо | 2 | 20 | -Сонгинохайрхан дүүргийн 1, 11, 26, 33, 36 дугаар хорооны 5 байршилд шинээр автобусны дулаан зогсоолыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байнгын ашиглалтад оруулж тус тус хүлээн авсан. Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/111 дүгээр захирамжаар нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх ажлыг баталсан бөгөөд дээрх захирамжийн хүрээнд хоёр удаагийн тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тул Хот байгуулалт хотын стандартын газраар ажлын даалгаврыг шинэчлэн батлуулж 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 14 байршилд саравчтай болон дулаан зогсоол байгуулах худалдан авах ажиллагааг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.1.2 | Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох ажлын хүрээнд УБЗАА-нд санал хүргүүлнэ. | - | Саналын тоо | 1 | 1 | <p>зарлаад байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 547 саравчтай зогсоол ашиглагдаж байна.</p> <p>Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох зорилгоор нийслэлийн 9 дүүргээс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/02/1058 дугаартай албан бичгээр шинээр хийгдсэн дулаан зогсоолуудын мэдээллийг авч автобусны зогсоолын мэдээллийн санг бүрдүүлсэн. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн "Тээврийн хэрэгслийн зогсоолд үзлэг шалгалт зохион байгуулах тухай" А/120 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолуудын байршлыг тогтоох, замын хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцүүлэх асуудлыг холбогдох газруудтай хамтарч шийдвэрлэхээр НХХГ, НХБХСГ, ТЦА хамтарсан 3 баг, дүүргүүдийн автобусны зогсоолуудын тооллогын ажлыг зохион байгуулж ажилласан. Нийслэлийн хэмжээнд нийт 1282 автобусны зогсоол тоологдсоноос 7,8 хувь нь буюу 101 зогсоол хяналтын камертай байна. Мөн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах дулаан зогсоолуудыг "Телекамерын хяналтын дэд төв"-д холбон, цэвэрлэгээ үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг тогтмолжуулан, байнгын ажиллагаатай байлгах тухай 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/02/2437 дугаартай албан бичгийг дүүргүүдийн засаг дарга нарт хүргүүлсэн.</p> | 100 |
| 2.1.3 | Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг | - | Зогсоолын тоо | 2 | 20 | Тус газраас энэ онд иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. | 80 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5.1. | 2 | 3 | 4 | 5 | 6 Үүнд: богино эргэлтийн 14 чиглэл, гэр хорооллын суурьшлын бүсэд үйлчилгээг хүргэсэн 8 чиглэл байна. Зорчих эрэлт, зорчигч урсгалын тооцоо судалгаанд үндэслэн нийт 14 чиглэл шинээр нээж, 16 чиглэлд өөрчлөлт оруулсан. ЦЕГ-ын ТЦА, НТБГ-ын дарга, ЗХУТ ОНӨТҮГ-ын захирал хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг байгуулагдаж ажилласан. Дээрх ажлын хүрээнд хамтарсан багийн гишүүд бодит цагийн байдлаар замын хөдөлгөөний нөхцөл байдалд телекамераар хяналт тавьж замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг зохицуулан, нийтийн тээврийн хэрэгслийг авто замын нэгдүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тухай бүр хийснээр Энхтайваны өргөн чөлөө дагуух нийтийн тээврийн хэрэгслийн ашиглалтын дундаж хурд 10.6 км/цаг байсан нь 12.9 км/цаг болж 18%-иар өссөн эерэг үр дүн гарсан. Цаашид чиглэлийн тээврийн хэрэгсэлд зориулсан эгнээг нэмэгдүүлэхэд шаардлагатай 3, 4-р хорооллын эцсээс Цайз захын уулзвар хүртэл, 120 мянгатын уулзвараас Нисэхийн тойрог хүртэлх авто замын 1-р эгнээнд хяналтын камер суурилуулахад шаардлагатай зардлыг Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралд хэлэлцүүлэн дэмжигдсэн. Газрын даргын тушаалаар 3 чиглэлд зогсоол нэмэгдүүлсэн. Үүнд: 1.Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/05 тоот тушаалаар автобусны зогсоол | 7 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|--|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | <p>хоорондын зайг ойртуулж Ү:19, Ү:20, Ч:6, Ч:13, Ч:40, Х:8 чиглэлүүдэд "Гармын зогсоол"</p> <p>2.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж М:6, Ч:61, Ч:70, чиглэлүүдэд "Дэлгэр хотхон" зогсоол</p> <p>3.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:30, М:5 чиглэлүүдэд "Эрдэнэдриплинг" зогсоолыг тус тус нэмж баяжилт хийсэн. Тайлант хугацаанд нийт 76 зогсоолыг мэдээллийн санд бүртгэн системд оруулсан байна.</p> | |
| 3.1. | Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох МУХТ 2025-2.2.2.3. | - | Парк шинэчлэлтээр нийлүүлэгдсэн автобусны эргэн төлөлт /Сая төгрөгөөр/ | 24,102.8 | 29,410.2 | <p>3. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго: Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. МУХТ 2025-2.2.2</p> <p>2025 оны 10 дугаар сарын байдлаар "2024 онд их багтаамжийн автобус худалдан авсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас "Нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээ"-ний дагуу 9,023.3 сая төгрөг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүжилтээс элэгдлийн зардалд 17,727.0 сая төгрөг, нийт 26,750.3 сая төгрөг төгрөгийг суутган Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлээд байна.</p> <p>2009 онд худалдан авсан 400 ширхэг автобусны өр төлбөрөөс автобус худалдан авсан Сутайн буянт ХХК, Автобус нэгдэл ХХК, Эрдэмтранс ХХК нийт 324.0 сая төгрөгийн эргэн төлөлтийг хийлгэсэн.</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээний орлого зардлын зөрүүг бууруулах, орлогоороо зардлаа нөхөн алдагдалгүй ажиллах бодлогын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд иргэд өдөрт 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжийг бүрдүүлж, төлбөр тооцооны шинэ системийг хөгжүүлж, зорчигч төлбөрийн олон төрлөөс</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.2. | Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх. НХТ 2025-107 | - | Чиглэлийн тоо | - | 5 | сонгон төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Шинэ тарифыг мөрдөж эхэлснээр 2025 оны 10 дугаар сарын байдлаар 141,3 сая зорчигч тээвэрлэн 44.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс зорчилт 13,9 хувиар, орлого 66,7 хувь буюу 18,6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэр хорооллын дундах авто замуудын нөхцөл байдлыг газар дээр нь судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаанд СХД-ийн 14, 21, 31, 43-р хороо БГД-ийн 10, 22-р хороо БЗД-ийн 17, 18, 19, 27-р хорооны 11 байршил хамрагдаж, дунд оврын тээврийн хэрэгслийн үйлчилгээг нээх боломжийг судалсан. Энэ онд дунд оврын дараах чиглэлүүдийн чиглэлийн замналд өөрчлөлт оруулж, шинээр нээсэн. Үүнд: 1. СХД-ийн 31 дүгээр хорооны иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Д:4 "Хайрханы шинэ эцэс-Алтай-Цамбагарав-176-р цэцэрлэг" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс дунд багтаамжийн 1 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн. 2. БЗД-ийн 10, 24, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйлчилгээ хүрээгүй суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгааг хийж, төлөвлөлтийг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар Д:1 "Шархад-Хангамж-Ботаник", 3. Д:11 "Официеруудын ордон-Цахлай-Баянзүрх дүүргийн 24-р хороо", 4. Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс". | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|-----------------------------|--|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.3. | Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох МУХТ 2025-2.2.2.4., НХТЖҮЧ-9.21.3, НХТ 2025-109. | - | Нийтийн тээвэр үйлчлүүлсэн зорчилт /жилд, сая/ | 139.0 | 173.0 | 5.Д.13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийг баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн. Зорчигч урсгалын судалгаанд үндэслэн нийтийн тээврийн үйлчилгээний 52 чиглэлийн гаралтын тоонд өөрчлөлт оруулах төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлсэн. Нийтийн тээврийн орлогыг нэмэгдүүлж, зардал бууруулах ажлын хүрээнд тус газрын даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл бүрийн багтаамж ашиглалтын коэффициентийг гаргаж тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчлох санал танилцуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээний 138 чиглэлээс 41% буюу 57 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффициент 0-59, 35% буюу 48 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффициент 60-100, 24% буюу 33 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффициент 101-с дээш байна. Тайлант хугацаанд нийтийн тээвэрээр 141,3 сая зорчигч үйлчлүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 12,7%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 85 |
| 3.5. | Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих НХТ 2025-111. | Нийслэлийн төсөв 3,500.0 | Барилгын ажлын явц | - | 100 | Орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашийн барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектурыар батлуулсан. Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашийн барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1,0 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31- | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|---|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.6. | Хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийж гүйцэтгэнэ. | - | Нийтийн тээвэрт ашиглаж буй тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийсэн тоо | - | 10 | <p>ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан.</p> <p>Барилгын ажлын явц 35 хувийн гүйцэтгэлттэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Темер бетон каркас угсралтын ажил дууссан. - Дээвэр хийх ажил дууссан. - Темер багана, дам нуруу, холбоос угсрах ажлууд дууссан. 2026 оны орон нутгийн төсөвт үлдсэн 2,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгаж, гараашийн барилгын ажлыг дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|---------------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | <p>шар" чиглэлд 3 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж эхэлсэн.</p> <p>-Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын "Шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай" 2025.09.26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган захиалагчийн хяналтыг тавьж ажилласан. Үүний дагуу БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус болон 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулсан. Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 15 ширхэг автобус нь нийтийн тээврийн үйлчилгээнд гарган ажиллаж байна.</p> | |
| 3.7. | Нийтийн тээврийн мастер төлөвлөгөөнд санал тусгах НХТ 2025-98, НХТЖУЧ-9.23.1 | - | Төлөвлөгөөнд санал тусгах | 1 | 1 | | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|-------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 тайланг ирүүлсэнтэй танилцаж, нэмэлтээр тусгах 6 саналыг нэгтгэн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/02/355 дугаар албан бичгээр тус тус төслийн нэгжид хүргүүлсэн. Уг зөвлөх үйлчилгээний STRA-C3 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан гэрээний хугацаа сунгах, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчлөх, түншлэл хасах, холбогдох голлох мэргэжилтнүүдийг солих нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулж, холбогдох хяналтыг хийж ажилласан ба гэрээний сунгалт НЗДТГ-аар 5 дугаар сарын 19-ний өдөр баталгаажсан. Зөвлөх багтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 24, 27-ны өдрүүдэд "Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги ба стратегийн төлөвлөлт, Их багтаамжтай нийтийн тээврийн систем ба нийтийн тээвэрт суурилсан хөгжил" сэдвээр төслийн оролцогч талуудтай уулзалт зохион байгуулсан. Нийтийн тээврийн стратеги төлөвлөгөөний эцсийн тайланд 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/02/2216 дугаартай албан бичгээр нэмэлтээр тусгах шаардлагатай 36 саналыг нэгтгэж Тогтвортой авто зам тээвэр төслийн нэгжид хүргүүлсэн. Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратегийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлж дэмжигдсэнээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | 7 |
| 3.8. | Дүүжин замын тээвэр, Метро, BRT, Трамвай төслийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд мэдээ, мэдээллээр | - | Бэлтгэл ажлын явц | - | 50 | 1.Дүүжин замын тээвэр төслийн нэгдүгээр шугам буюу Яармаг, Арцат – Хархорин, Өнөр хороолол чиглэлд тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн. Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | <p>1</p> <p>хангах, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. НХТ 100, 101, 102, НХТЖҮЧ 9.21.1. МУХТ 2025-2.2.2.1, 2.2.2.2.</p> | 2 | 3 | 4 | 5 | <p>6</p> <p>баганын нийт 28 ширхэг шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Европын Холбооны стандартыг нутагшуулах зорилгоор "Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага"-тай холбоотой 15 стандартыг Стандарт, хэмжилзүйн газрын Автотээврийн стандартчиллын техникийн хороогоор батлуулан, MNS бүртгэлд шилжүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нэгдүгээр шугамын барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна. Нийт 19 тулгуур багана суурилуулахаас 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаа 11 тулгуур баганыг суурилуулж, 8 тулгуур багана суурилуулалтын ажил үлдээд байна. Төслийн бетон цутгалтын ажлыг 10 дугаар сарын 30-ны өдөр гэхэд дуусгахаар төлөвлөсөн бөгөөд суурийн ажил бүрэн дуусаж, 28 хоногийн бат бэх болсны дараа металл хийцлэлийг хоёр өдөрт багтаан угсрах боломжтой. Өнөөдрийн байдлаар суурийн ажил 75 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа бол тулгуур цамхгийн суурилуулалтыг 11 дүгээр сард бүрэн хийж дуусгахаар төлөвлөсөн.</p> <p>Дүүжин замын тээврийн системийн тросс, кабин хөдөлгөөний үндсэн бүтэц болох эргэлтийн зам төмрийг Яармаг болон Хархоринд байрлуулах ажил 31.5 хувьтай үргэлжилж байна. Харин буудлын дэргэд кабин байрлуулах гараашийн суурь, бетон цутгалтын ажил дуусаж, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.</p> <p>2.Метро төслийн шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ холбогдох яамдын мэргэжлийн зөвлөл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын салбар хороод, намын бүлгүүдээр үе шаттай хэлэлцэж дэмжсэн. Төслийн нэгжээс 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод хэрэгжүүлэх их баггаамжийн</p> | 7 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | <p>6</p> <p>сайжруулалт хийгдэж байна. Тусгай замын автобус төсөл хэрэгжүүлэх баг нь Сангийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банктэй зээлийн хэлэлцээрт орсон байгаа бөгөөд Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлийн хурлаар зээлийн хэлэлцээрийг энэ ондоо батлуулах ба Сангийн яамд гарын үсэг зуруулж батлуулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>4."Буянт-ухаа спорт цогцолороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл"-ийн техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг төслийг боловсруулахаар "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ шалгарсан. Тус газраас Трамвайн замын төлөвлөлтийн трассын зураг төсөлд тусгах саналыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/02/1003 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>"Улаанбаатар Трам" төслийн 1 болон 2 дугаар шугамын ТЭЗҮ-техник эдийн засгийн үндэслэлийг 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр сард Зам тээврийн яамны дэргэдэх Шинжлэх Ухаан Техникийн дэд зөвлөлүүд, Зам Тээврийн Хөгжлийн Төвийн магадлал зэрэг мэргэжлийн зөвлөлүүдээр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Зам тээврийн яамны Зам, тээврийн хөгжлийн төвийн 2025 оны 159/2025 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр Зуслангийн бүсээс Сүхбаатарын талбай чиглэлд нийтийн тээврийн Улаанбаатар трам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, 160/2025 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбай чиглэлд нийтийн тээврийн Улаанбаатар трам төслийн техник, эдийн засгийн үндэслэл тус тус батлагдсан. 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр</p> | 7 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|---|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | <p>6</p> <p>нийтийн тээврийн Метро төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг эцэслэн шийдвэрлэх саналыг 2025 онд багтаан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулан батлуулах зорилготой бөгөөд төлөвлөгөөний дагуу холбогдох материалуудыг бэлэн болгосон. Уг төслийн санхүүгийн асуудлууд улс хоорондын хэлэлцээр Засгийн газрын түвшинд явж байна. Монгол улсын Засгийн газрын тогтоолын "2" дахь хэсэгт "Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг Монгол Улсын Засгийн газарт өргөн мэдүүлэх, шаардлагатай санхүүжилтийн саналыг боловсруулан танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид үүрэг болгосугай" гэсний дагуу Засгийн газарт өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>3."Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн сайжруулалт" сэдэвт зөвлөлдөх уулзалтаар 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Тусгай замын автобус төслийн үйл ажиллагаа, санхүү, дэд бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлэлцсэн. Азийн хөгжлийн банк нь "Тусгай замын автобус BRT төсөл"-ийн санхүүжилтийн зээлийн судалгааны ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд Улаанбаатар хотод ажилласан. Тус газраас хамрах асуудлын хүрээнд 4 өдрийн уулзалтад оролцож, санал хүргүүлж ажилласан. 2025 оны 11 сар хүртэлх хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын хүсэлтийн дагуу автобус бааз барих төслийг нийт BRT ТЗЗУ төсөвт өртөгт оруулсан. Мөн 2025.09.03-ны өдөр BRT ТЗЗУ-г Зам тээврийн яамны ШУТЗ дэргэдэх Автотээврийн салбарын ШУТЗ-аар оруулан хэлэлцүүлж дэмжүүлсэн. 2025 оны 12 сарын байдлаар Зам Тээврийн Яамны зөвлөмжийн дагуу ТЗЗУ</p> | 7 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | <p>A/1324 дугаартай захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төслийн бүрэн шинжилгээг холбогдох хууль журамд нийцүүлэн гаргасан саналыг Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулах ажлыг гүйцэтгэж байна.</p> | |
| | | | | | | <p>4. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:</p> <p>1.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн нийт 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, хэрэгжилтийн дундаж 100 хувь, 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 8 арга хэмжээ 88,7 хувийн хэрэгжилттэй тус тус хүргүүлсэн.</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжийн түүврээс нийт 8 үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж 98.75 хувь байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 дугаар захирамжийн 11 арга хэмжээний хэрэгжилтийг сар бүрийн 25-ны өдрийн дотор нийт 11 удаа хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж 100 хувь байна.</p> <p>3.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/656 дугаартай "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" захирамжийн хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт 100 хувь байна.</p> <p>4.Нийслэлийн Засаг даргын 2024-2025 оны ажлын хэсэг байгуулах тухай захирамжийн хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, 04 дүгээр сарын 23-ны өдөр, 05 дугаар сарын 15-ны өдөр тус тус гарган ERP системээр хүргүүлсэн.</p> | 100 |
| 4.1. | <p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, үр дүнд Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана.</p> | - | Хувь | - | 100 | | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.2. | <p>Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 206 Дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана.</p> | - | Хувь | - | 100 | <p>2025 онд Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 20 удаа хуралдаж, тус газартай холбогдолтой 72 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж хувь 93,5 хувьтай байна. Тус газарт удаашралтай ажил буюу хэрэгжээгүй үүрэг даалгавар байхгүй болно.</p> <p>Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг нийт 9 удаа хүргүүлсэн.</p> <p>2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газрын 4 тогтоолын 5 арга хэмжээ, Засгийн газрын хуралдааны нийт 9 тэмдэглэлээс 13 арга хэмжээ, Засгийн газрын 1 албан даалгаврын 2 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж ба 93,5 хувь байна.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын 4 тогтоолын 5 арга хэмжээ, Засгийн газрын хуралдааны нийт 9 тэмдэглэлээс 13 арга хэмжээ, Засгийн газрын 1 албан даалгаврын 2 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж ба 93,5 хувь байна.</p> <p>2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Засгийн газрын хуралдааны 2 тэмдэглэлээс 3 арга хэмжээ, Засгийн газрын 2 албан даалгаврын 2 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь байна.</p> <p>2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Засгийн газрын хуралдааны 2 тэмдэглэлээс 3 арга хэмжээ, Засгийн газрын 2 албан даалгаврын 2 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь байна.</p> <p>2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 тогтоолын хэрэгжилтийг гарган хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувь байна.</p> <p>2025 оны 06 дугаар сарын 24-ны өдөр Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийн эхний хагас жилийн биелэлтийг 5 арга хэмжээний хүрээнд 85 хувийн хэрэгжилттэй хүргүүлсэн.</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.3. | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүд, дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана. | - | Хувь | - | 100 | 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр МУ-ын Засгийн газрын албан даалгавар 2 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь байна. 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр МУ-ын Засгийн газрын 1 тогтоолын хэрэгжилт Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн тэмдэглэлээс нийт 4 арга хэмжээ хэрэгжилтийн дундаж 85 хувь байна. 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3 тогтоолын хэрэгжилтийг 93 хувийн дундажтай тус тус хүргүүлсэн байна. Тогтоол шийдвэрийн хяналтаас хасуулах 4 арга хэмжээг хасуулах үндэслэл болон нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний газрын холбогдох албан хаагчид Нийслэлийн нутгийн захиргааны байгууллын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP-ээр хүргүүлсэн. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүд, дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайлант хугацаанд хүргүүлэхээр нэгтгэж байна. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн нийт 8 арга хэмжээний хэрэгжилтийг 2020-2025 оны байдлаар гарган Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 2025 оны Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд, Засгийн газрын гишүүдтэй байгуулсан батламж, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | <p>санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилт үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд ERP системийн чатаар хүргүүлсэн.</p> <p>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн нийт 7 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн гаргаж Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нотлох баримтын хамт хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд ERP хувь чатаар хүргүүлсэн.</p> | |
| 4.4. | <p>2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллана.</p> | - | Сая төгрөг | 3,792.8 | 7,167.5 | <p>Тус газрын 2025 оны 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого дараах байдалтай байна. Үүнд:</p> <p>-Орлого зардлын зөрүү санхүүжилтээс 6,067.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 488.5 сая төгрөг, бэлэн мөнгөний орлогоор 9,271.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж төлөвлөгөөг 60.8 хувиар давуулан биелүүлсэн байна.</p> <p>-Түр зөвшөөрлийн хураамжаас 840.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 899.4 сая төгрөг төвлөрч, 107 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>-ТҮЦ машины орлогоос 253.8 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 192.7 сая төгрөг төвлөрч, 75.9 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>-Замын хуудасны хураамжаас 5.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2.5 сая төгрөг төвлөрч 45.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.</p> <p>Дээрх задаргаанаас авч үзвэл 2025 онд үндсэн үйл ажиллагааны орлого 7,167.5 сая.төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 10,854.7 сая төгрөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 316.6</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|-------------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.5. | 2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. | - /Нийслэлийн төсөв/ | Сая төгрөг | 272,4 | 221,9 | сая төгрөг, нийт 11,171.3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 55.9 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийтийн тээврийн үйлчилгээний салбарт сахилга хариуцлагыг дээшлүүлэх, захиргааны хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр Авто тээврийн хяналтын 10 улсын байцаагч Авто тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, биелэлтийг хангуулах ажлын хүрээнд "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 улсын стандартын үзүүлэлт шаардлагыг хангуулан ажиллаж, шалгалтаар илэрсэн зөрчилд "Зөрчлийн тухай" хуулийн холбогдох заалтуудын дагуу 143 аж ахуйн нэгж, байгууллагад 59,900.0 сая төгрөгийн, 762 иргэнд 30,370.0 сая төгрөгийн, нийт 905 зөрчилд 90,270.0 сая төгрөгийн торгох шийтгэл ногдуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. 2025 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу туслах үйл ажиллагааны орлого 221,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 10 дугаар сарын байдлаар 393,4 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 113%-иар давуулан биелүүлсэн. | 100 |
| 4.6. | Улаанбаатар смарт карт ХХК-аас ирүүлсэн тухайн сарын ажлын гүйцэтгэл, шугамын орлого, зорчигчийн мэдээг хянаж машин цагийн зардлын санхүүжилтийг тооцон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад олгоно. | - /Нийслэлийн төсөв/ | Сая төгрөг | 271,315.3 | 284,901.4 | Улаанбаатар смарт карт ХХК-иас гарган баталгаажуулж ирүүлсэн оны эхний 04 сарын ажлын гүйцэтгэлийн нэгтгэлийн дүнг өдөр тутмын ажлын гүйцэтгэлийн нэгтгэл болон Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн машин цаг, рейс, тээврийн хэрэгсэл, нэмэгдэж хасагдсан цагийн дүнтэй тулган хяналт тавьж ажилласан. Нийтийн тээврийн үйлчилгээнд оны эхний 10 сарын байдлаар 326,351 тээврийн хэрэгсэл 2.3 сая рейс, 4.5 сая машин цаг ажилласан ба 5377 цаг ажлын гүйцэтгэлд нэмэгдэж, 1605 цаг ажлын гүйцэтгэлээс хасагдаж тооцуулсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|-------------------------|---|--------------|-----------------|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.7. | Нийтийн үйлчилгээний төвлөрүүлэлтэд тавьж, төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийтийн тээврийн төлбөрийн систем нэвтрүүлнэ. НХТ-424 | - /Нийслэлийн төсөв/ | Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн системийн тоо | - | 1 | 2025 онд машин цагийн зардлын санхүүжилтэд 284,901.4 сая төгрөг батлагдсанаас 2024 оны 12 дугаар сарын гүйцэтгэл 31,834.3 сая төгрөгийг, мөн 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 264,612.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарснаас 253,053.1 сая төгрөг, нийт 284,887.4 сая төгрөгийг тус тус олгосон байна. Харин 2025 оны 10, 11 дүгээр сарын санхүүжилтийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад төсөв хүрэлцээгүйн улмаас олгоогүй бөгөөд дутагдаж буй эх үүсвэрийг 2025 оны төсвийн тодотголд тусуулах талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр хүргүүлэн хянуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр хэлэлцүүлж байна. 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар нийт 141,3 сая зорчигч тээвэрлэсэн байна. | 2025 оны эхнээс 115 чиглэлд үйлчилгээнд ажиллаж байгаа их болон дунд багтаамжийн 1186 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж давхардсан тоогоор 49245 тээврийн хэрэгсэлд 59208 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 98885 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 37547 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс тагталзан, зорчуулахгүй буулгаж, 61946 зорчигчийн картад Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 3,028.3 сая төгрөгийн цэнэглэлт хийж ажилласан. Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн системийг нэвтрүүлснээр нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийг зориулалтын карт, банкны карт, гар утасны аппликейшн, бэлэн мөнгө зэрэг олон хэлбэрээр төлөх боломжийг бүрдүүлсэн. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсонтой холбоотойгоор 2025 оны эхний 10 дугаар сард шугамын орлого 46,652.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 67.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Энэхүү өсөлтөд төлбөрийн уян хатан нөхцөл бүрдүүлсэн, мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах" 25/14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нь орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна. | 7 |
| 4.8. | Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ. | - | Хувь | - | 100 | Тус газар нь улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд дараах ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд: 1.Нийтийн тээврийн хөгжүүлэх сангийн хөрөнгө, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн НТБГ/20250103002 дугаартай Нийслэлийн Нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автомагаар боловсруулах системийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан Дата дээс ХХК-тай 184.0 сая төгрөгийн гэрээ байгуулж эрх олгосон. Уг системийн тооцооллоор хийгдсэн зогсоолын 50 зураглалыг Энхтайваны өргөн чөлөө дагуух зогсоолын саравчуудад байршуулсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|---|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| 5.13. | <p>Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, програм хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Дүрмийн 4.1.3.4</p> | - | Хувь | - | 100 | <p>шаардлага үсэж шаардагдах хөрөнгийг Нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн.</p> <p>1.Нийтийн тээврийн удирдлагын дэд систем /monitoring.ubcard.mn/ болон Тээврийн хэрэгслийн систем /transport.khatuga.com/ шинэ программтай танилцан хөгжүүлэлт хийх шаардлагатай цэсүүдэд сайжруулалтын 10 санал өгч тусгуулсан.</p> <p>2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн II хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсан. Чингис хаан олон улсын нисэх буудал, Багануур, Багахангай чиглэлээс бусад бүх чиглэлд 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийтийн тээврийн үйлчилгээний зориулалтын картаар 1000 төгрөгөөр өдөрт 4 удаа чиглэл харгалзахгүй зорчих боломж бүрдүүлж, төлбөрийг бүх төрлийн банкны карт, гар утасны UBCard аппликейшн ашиглан QR кодыг уншуулж, 6.8 сая уншилт хийгдэж, 8.1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.</p> <p>3.Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн менежментийн системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 100 байршилд киоск машин, зорчигч урсгал ихтэй 100 байршилд лед дэлгэц байршуулсан.</p> <p>4.Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 1100 автобусанд жолоочийг хянах камер, замын мэдээлэл дамжуулж, зураг дарах зориулалттай урд камер, зорчигч тоолох 2 камер, жолоочийн дэлгэц, согтолтын зэрэг хэмжигч төхөөрөмж, төлбөр тооцоо хийх карт уншигч төхөөрөмж, агаарын чанар хэмжигч, заалны камерууд зэрэг 10 гаруй төрлийн төхөөрөмж суурилуулсан.</p> <p>5.Нийслэлийн Багануур, Багахангай дүүрэг, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлийн хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд зориулан</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.14. | <p>Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4.1</p> | - | Хувь | - | 100 | <p>тасалбар урьдчилан захиалах, дайвар ачаа тээвэрлэх цахим төлбөрийн шинэ систем хөгжүүлж, нэвтрүүлснээр 281 тасалбар, 14 дайвар захиалга хийгдэж нийт 2,8 сая төгрөгийн орлогын төвлөрүүлсэн.</p> <p>Тус газраас нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эмэгтэй, хүүхдүүд зэрэг нийгмийн тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн саадгүй, тав тухтай, зорчих нөхцөлийг хангаж буй эсэхэд хүртээмжийн үнэлгээ хийх зорилгоор Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газруудын холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 2025 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын автобуснуудад техникийн 7, мэдээллийн 10 асуумжаар 5 төрлийн автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн үнэлгээ хийсэн. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад автобусанд байрлуулсан хяналтын камерын ашиглалт хамгаалалтын хэвийн ажиллагаанд хяналт шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Шалгалтад 17 аж ахуйн нэгж, байгууллагын 652 тээврийн хэрэгслийг хамруулснаас жолооч руу чиглэсэн камерын харах өнцөг өөрчилсөн 401 зөрчил илэрсэн. Дээрх зөрчил илэрсэн аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 2025 он 04 дүгээр сарын 14-өөс 16-ны өдрийн хооронд гүйцэтгэлийн шалгалт хийж зөрчил бүрэн арилгаагүй 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.15. | <p>Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.4.2</p> | - | Хувь | - | 100 | заалтын дагуу 500 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулсан. Нийтийн тээврийн автобуснуудыг зогсоолоор нь саадгүй нэвтрүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 12-ноос 19-ний өдрүүдэд Сүхбаатар дүүргийн "Бүрэн плаза" худалдаа, үйлчилгээний төвийн өмнө байрладаг чиглэлийн зогсоолд байрлуулсан тээврийн хэрэгслүүдийг чөлөөлүүлэх арга хэмжээ авсан. Энхтайваны өргөн чөлөөнд ажиллахдаа автобусны буудлын "Зогсоолын талбай"-д хориглосон цагаар зогссон 20998 автомашины зөрчлийг фото зургаар баримтжуулан "E-Police application"-ээр Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү шилжүүлснээс 13369 зөрчил баталгаажиж гэрийн хаягаар илгээн, нийт 267.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Замналын зогсоолд байрлуулсан суудлын тээврийн хэрэгслүүдийн эзэмшигчтэй холбогдож зогсоол чөлөөлөхийг мэдэгдэж, утасны дугаараа үлдээгээгүй 9 тээврийн хэрэгслийг ачилтын машинаар ачуулсан. | 100 |
| 5.16. | <p>Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна. Дүрмийн 4.1.4.4</p> | - | Хувь | - | 100 | Гэрэгэ киоск ХХК-тай хамтран "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн. 1.Иргэн хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор "Тайлан", "ЕС", "ТҮР" замын хуудас олгох үйлчилгээг "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ээр дамжуулан нэг цонхноос авах боломжийг бүрдүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын тайлангийн мэдээлэлд үндэслэн ачаа тээвэрлэлтийн нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэх боломжийг бүрдүүлсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨҮГ, Тээврийн цагдаагийн албатай хамтран баталсан "Нийслэл Улаанбаатар хотод тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад хамтран үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын удирдамж"-ийн дагуу Нийслэл хотын дотор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих хууль тогтоомж, стандарт шаардлага хангаж байгаа эсэхэд хамтарсан хяналт, шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 02-10-ны өдрүүдэд хийж, 16 аж ахуйн нэгж, байгууллагын 96 тээврийн хэрэгсэл, 86 жолооч хамруулсан. Шалгалтаар 13 аж ахуйн нэгж байгууллага тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тухайн ангиллаар мэргэшээгүй 36 жолоочийг ажиллуулсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.1-д заасныг үндэслэн тус бүр 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан. | |
| 5.17. | Газар нь хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллана. Дүрмийн 6.5 | - | Хувь | - | 100 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2025 оны хариуцлагын гэрээний хэрэгжилт, түүний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/905 дугаартай захирамжаар бүрэн хангалттай үнэлэгдсэн. | 100 |
| 5.18. | Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, дүрэм, журам | - | Хувь | - | 100 | 2025 оны жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /А/126 хүний нөөцийн чиглэлээр /Б/202 тушаалыг холбогдох хууль, журам, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | Баталж мөрдүүлнэ. Дүрмийн 7.1.1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.19. | Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд холбогдох хууль журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулна. Дүрмийн 7.1.2 | - | Хувь | - | 100 | дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чиглэлээр /Б/202 тушаалыг холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Ахмадын бүртгэлд авах тухай-1, Чөлөө буцалтгүй тусламж олгох тухай-13, Цалинтай чөлөө олгох тухай-5, тэтгэмж олгох тухай-10, Ажилд томилох тухай-56, Ажлаас чөлөөлөх тухай-46, Чөлөө олгох тухай-33, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн батлах тухай-1, Албан хаагчдыг үргэлжлүүлэн ажиллуулах тухай-3, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-11, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-7, зардал гаргах тухай-1, Сахилгын шийтгэл ногдуулах тухай-2, Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай-3, Хүүхэд асрах чөлөө дуусаж үргэлжлүүлэн ажиллуулах тухай-1, Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай-2. Төрийн албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай-1, Шилжүүлэн ажиллуулах тухай-1, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай-1, хүүхэд асрах чөлөө дуусгавар болгох тухай-1, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, тушаал хүчингүй болгох тухай-1 байна. | 100 |
| 5.20. | Хэлтэс /нэгж/-ийн дарга, төрийн захиргааны албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Дүрмийн 7.1.3 | - | Хувь | - | 100 | Тус газрын төрийн захиргааны 30 албан хаагч, төрийн үйлчилгээний 138 албан хаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|---|--------------|-----------------|---|--------------|
| 5.21. | 1 Сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. Дүрмийн 7.1.4 | 2 - | 3 Хувь | 4 - | 5 100 | 6 Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн төр, захиргааны байгууллагын ажлын цагийн хуваарь зохицуулалт хийх тухай" А/630 дугаар захирамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд ажлын цаг 07:00-16:00 цаг, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 08:00-17:00 цаг байхаар тогтоосны дагуу байгууллагын албан хаагчдад танилцуулж, "ERP" цахим системд ажлын цагийн өөрчлөлт оруулан цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна. Прокурорын байгууллага, Зам тээврийн яам, бусад хууль хяналтын байгууллагаас тус газарт ирүүлсэн шаардлага, мэдэгдэл нэг бүрийг судалж хууль ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоон тухай бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. | 7 100 |
| 5.22. | Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд мэргэшүүлэх багц сургалт болон холбогдох сургалтад албан хаагчдыг хамруулна. Дүрмийн 7.1.5 | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 30 | Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг хамруулж, газрын даргын 2025 оны Б/73 дугаар тушаалын дагуу 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлсэн. Удирдлагын академийн төрийн захиргааны мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч хамрагдаж, 1 албан хаагч Удирдлагын академийн захирлын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/141 тоот тушаалаар R2790 сертификатыг аваад байна. Хугацаа болоогүй 1 албан хаагчийн байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан давхардсан тоогоор нийт 35 сургалтад давхардсан тоогоор 116 албан хаагч, Монгол хэлний | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.23. | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Дүрмийн 7.1.11 | - | Хувь | - | 100 | Тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III", Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Архивын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх" сэдэвт сургалтад 10 албан хаагчийг хамруулсан байна. Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж Удирдлагын академийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/387 тоот тушаалаар Е1555 сертификатыг авсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.24. | Тэвэрлэлт гүйцэтгэх шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулах сунгах, цуцлах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулна. /Санхүүжилтийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих/ Дүрмийн 7.1.12 | - | Хувь | - | 100 | талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгаж, бэлтгэл ажлыг хангуулах тухай зөвлөмж" ирүүлсний дагуу бэлтгэл ажлыг ханган 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр үзлэг шалгалтад амжилттай хамрагдсан. 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01/07 дугаартай "Монгол бичгээр хэвлэмэл хуудас хэвлүүлэх", 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/01/773 дугаартай "Монгол бичгээр хэвлэмэл хуудас хэвлүүлэх" хэвлэмэл хуудас хэвлүүлэх албан бичгийг тус тус Нийслэлийн архивын газарт хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар кирил болон Монгол бичгээр А4, А5 хэвлэмэл хуудсанд 2497 албан бичиг, 328 тушаалыг хэвлэмэл хуудсанд тус тус буулган ажилласан. Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах ажил гүйцэтгэх (нийтийн тээврийн үйлчилгээ) гэрээний төслийг эцэслэн боловсруулан тэдгээрээс 2 удаа саналыг авч тусгай зөвшөөрөлтэйгөөр нийтийн зорчигч үйл ажиллагаа эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагуудтай 5 жилийн хугацаатайгаар гэрээг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, такси үйлчилгээ эрхлэгч 5 хуулийн этгээдтэй гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 6. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 6.1. | Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд ЕС, ТҮР зөвшөөрлийг "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим | - | Хувь | - | 100 | "Гэрэгэ киоск" ХХК-тай №НТБГ/2025/ХА-25001 дугаартай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем" шинэчилсэн программ | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|---|--------------|-----------------|---|------|
| | 1 систем" ашиглан цахимаар олгоно. | 2 | 3 | 4 | 5 | 6 хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж "ЕС", "Түр" замын хуудсыг цахимаар олгох үйлчилгээг эхлүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар "ЕС" замын хуудас 15047 тээврийн хэрэгсэлд олгосноос В ангиллын 6975, С ангиллын 7573, М ангиллын 13, СЕ ангиллын 486 тээврийн хэрэгсэлд олгож, төрийн санд 193.2 сая төгрөг, "Түр" замын хуудас 5462 тээврийн хэрэгсэлд олгосноос В ангиллын 1193, С ангиллын 4146, СЕ ангиллын 120 тээврийн хэрэгсэлд олгож төрийн санд 897.0 сая төгрөг төвлөрүүлсэн. Нийт давхардсан тоогоор 20509 тээврийн хэрэгсэлд "ЕС", "Түр" замын хуудас олгож, төрийн санд 1,090.2 сая төгрөгийг төвлөрүүлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 7 |
| 6.2. | Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч болон авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулна. | - | Ангилал тогтоосон иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 141 | 150 | Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагаас 14 нь буюу 73 хувь нь тохирлын үнэлгээ хийлгэж, ангиллаа тогтоолгосон байна. Үүнд Зорчигч Тээвэр Нэг ОНӨААТҮГ, Зорчигч Тээвэр Тав ОНӨААТҮГ, Авто терминал трейд ХХК, Юбикаб бригада хоршоо, Гбус ХХК, Сугайн буянт ХХК, Дюц ХХК, Трансбус ХХК, Үнэгтийн уул ХХК, Эрдэм транс ХХК, Эмсид ХХК, Мяралзаа ХХК, Блюбус ХХК, Эс Энд Эй транс ХХК, Сайхан ирээдүй ХХК тус тус байна. | 85 |
| 6.3. | Стандарт, шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобус, бусад тээврийн хэрэгслийг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр | - | Хувь | - | 100 | 2025 оны жилийн эцсийн байдлаар Smartcar.mn сайтаар хүүхдийн автобустай холбоотой давхардсан тоогоор 42 хүсэлт ирүүлснээс 7 байгууллагын 8 тээврийн хэрэгсэлд шинээр зөвшөөрөл олгож, 8 зөвшөөрлийг сунгаж, 36 хүсэлтийг татгалзсан. Ажилчдын автобустай холбоотой давхардсан тоогоор | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | зорчуулах, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх, зөвшөөрөл олгох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэн зохион байгуулна. | 2 | 3 | 4 | 5 | 6 111 хүсэлт ирүүлснээс 23 байгууллагын 42 тээврийн хэрэгсэлд шинээр зөвшөөрөл олгож, 33 зөвшөөрлийг сунгаж, 68 хүсэлтийг татгалзан, 15 хүсэлтийг шилжүүлсэн. Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих хүсэлт өгсөн хүүхэд болон ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ үзүүлэгч 38 аж ахуйн нэгж, байгууллагын 46 хүсэлтийг хүлээн авч төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага. MNS 6440:2014, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2025 улсын стандартын шаардлагуудыг хангасан 38 аж ахуйн нэгж, байгууллагын 96 тээврийн хэрэгсэлд 733 заалт бүхий 46 техникийн дүгнэлтийг гаргаж, дугаарын хязгаарлалтаас чөлөөлж нэгдүгээр эгнээгээр зорчих нөхцөлийг хангаж ажилласан. | 7 |
| 6.4. | Авлигын эсрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах, хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд бүртгэх, хянах, гаргуулах, бүртгэх, хянах, | - | Хувь | - | 100 | Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/121 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын дагуу 25 төрийн захиргааны албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 15-нд цахим болон албан бичгээр хүргүүлсэн. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 2 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | <p>1</p> <p>зөвлөгөө мэдээлэл өгөх, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулна.</p> | 2 | 3 | 4 | 5 | <p>6</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тэнүүн огоо ХХК-ийн хооронд 2023 онд ННТГ23001, ННТГ23001-1 дугаартай гэрээ байгуулагдсан боловч худалдан авалт болон автобус хүлээн авсан асуудлаар Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулж Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд анхан шатны шүүх хуралдаан хуралдаж, энэхүү хэрэгт тус газрын ажиллаж байсан болон ажиллаж байгаа албан хаагчид шүүгдэгчээр оролцсон.</p> <p>Авлигын эсрэг хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг тус тус үндэслэн тус газрын даргаас 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар" нийт удирдлагууд болон холбогдох албан хаагчдыг үүрэг чиглэл өгч ажилласан.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлууд сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 55 албан хаагчийг хамруулсан.</p> | 7 |
| 6.5. | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг бүрэн хангана. | - | Тайлангийн тоо | - | 1 | <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030) Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баталсан "Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх" төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тус газрын "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 20-ы өдрийн</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|--------------------------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6.6. | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3 | 01/08/1404 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуй нэгж байгууллагуудад Зам тээврийн яамны улсын ахлах байцаагчийн 04-00-01/004/007/01 дугаартай зөвлөмжийн дагуу Улаанбаатар хот, хот доторх орчмын иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн ажилтан, иргэдэд тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах талаар зөвлөмжийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/03/666 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хяналт шалгалтын хэлтсийн автотээврийн хяналтын улсын 11 байцаагч хуулийн хэлтсийн 5 албан хаагч нар Монголын Криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор, Б.Батзориг "Зөрчлийн хуулийн үзэл баримтлал", Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор М.Буяннэмэх, М.Гансүвд нар "Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа" сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлууд сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 55 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| 6.7. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 5 | 6 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030) Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баталсан "Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх" төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тус газрын "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2025 оны 02 дугаар сарын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилгот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | 2 | 3 | 4 | 5 | 6 28-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 20-ы өдрийн 01/08/1404 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлант хугацаанд хүргүүлэхээр нэгтгэн ажиллаж байна. Нийтийн тээврийн бодлогын газрын шинээр цахим https://www.transprot.ub.gov.mn/ хуудасны "хууль тогтоомж цэс"-нд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр холбогдох хууль, дүрэм, стандарт зэргийг нэгтгэн байршуулан соён гэгээрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл, сурталчилгааг байршуулан ажиллаж байна. Хяналт шалгалтын хэлтсийн автотээврийн хяналтын улсын 11 байцаагч хуулийн хэлтсийн 5 албан хаагч нар Монголын Криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор, Б.Батзориг "Зөрчлийн хуулийн үзэл баримтлал", Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор М.Буяннэмэх, М.Гансүвд нар "Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа" сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. "Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх" сургалтад 7 албан хаагчийг хамруулж, үнэлгээний хорооны эрх олгох А3 гэрчилгээг 2 албан хаагч авсан. 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлууд сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 55 албан хаагчийг хамруулсан. | 7 |
| 6.8. | Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах | - | Хувь | - | 100 | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|------|---|--------------------|---------------------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | <p>нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.</p> | 2 | 3 | 4 | 5 | 6 <p>цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдөн ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган, 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/01/1385 дугаартай албан бичгээр, 2025 оны жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/01/2505 дугаартай албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хургуулсан.</p> | 7 |
| 6.9. | <p>Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна.</p> | - | Сэтгэл ханамжийн судалгааны тоо | - | 4 | <p>Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг (Google Form) цахимаар болон биетээр авч ажилласан. Үүнд:</p> <p>Нийтийн тээврийн салбарын үйлчилгээ болон шинээр хэрэгжиж буй төлбөрийн менежментийн системийн талаар зорчигчийн санал хүсэлт, үнэлгээ дүгнэлт өгөх сорилын тест боловсруулан Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн салбар Механик Инженер Тээврийн Сургуультай хамтран ажиллаж тус сургуулийн Авто инженер мэргэжлийн 3, 4 дүгээр дамжааны 35 оюутантай хамтран Энхтайваны өргөн чөлөөний замналын зогсоолууд дээр нийтийн тээвэрээр үйлчлүүлж буй 500 иргэдээс судалгааг авч дүнг нэгтгэсэн.</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг google form ашиглан нийт 507 хүнээс цахимаар авч нэгтгэн дүгнэлт гарган тодорхой чиглэлүүдийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Судалгаа авсан линк: https://forms.gle/Т56njCYnpv1BRVze7</p> <p>Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 64.9% нь өдөр бүр нийтийн тээвэрээр үйлчлүүлдэг, 75.5% нь нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх оноос</p> | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | <p>сайжирсан гэж дүгнэсэн. Судалгаанд нийт 1,171 иргэн оролцоноос иргэдийн 60 хувь нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаага илэрхийлсэн байна. Иргэдийн 70 хувь нь автобусны хүлээлгийн хугацаа урт байгааг онцлон тэмдэглэсэн нь үйлчилгээний хуваарь, чиглэл, давтамжийн зохицуулалт шаардлагатайг харуулж байна. Судалгааны үр дүнг ашиглан зарим чиглэлүүдийн цагийн хуваарьт бодит өөрчлөлт оруулан ажиллаж байна.</p> <p>"Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ийн хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж судалгаанд Авто үйлчилгээний ангилал тогтоолгосон 51 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Үүнээс:</p> <ol style="list-style-type: none"> 1.Хүндрэл үүсээгүй 63% 2.Үйлчилгээний ачаалал их 18.5% 3.Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй 7.4% 4.Төрийн албан хаагчийн харилцаа хандлага муу 3.7% 5.Байгууллагын дотоод сүлжээ доголдолтой 0% 6.Үйлчилгээний мэдээллийн ил тод байдал дутмаг 7.4% гэж үнэлсэн. | |
| 6.10. | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулна. | - | Хувь | - | 100 | "Шилэн данс цахим хуудсанд байршуулах мэдээллийн ажлын төлөвлөгөө"-г 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийтийн тээврийн бодлогын газрын https://www.transport.ub.gov.mn/ цахим хуудас болон цахим нүүр хуудаст нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдөж буй нийтийн тээврийн чиглэлийн замналын зураглалыг боловсруулах системийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэчийг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох урилгыг байршуулсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6.11. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хувь | - | 100 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу бүх шатны төрийн байгууллагуудын шилэн дансны мэдээлэл нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршиж байгаа тул хуульд заасан цаглабарын дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансанд байршуулах 171 мэдээ мэдээлэл байгаагаас хугацаандаа мэдээлсэн 141, хугацаа хоцорсон 1, мэдээлэх хугацаа болоогүй 29 мэдээлэл байна. https://shilen.gov.mn/dashboard шил ажиллагаа мэдээллийн системд 5 бүлгийн 87 цэсээр санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлж 2025 оны 3-р улиралд 94 хувиар үнэлэгдсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-----|--|--------------------|------------------|--------------|-----------------|---|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | <p>6</p> <p>байх талаар анхааруулсан. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 6 хоног 18 цаг 34 минут байгаа нь нийслэлийн дундаж хоног багтаан шийдвэрлэж байгаа үзүүлэлттэй байна. Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой дуудлага мэдээллийг 7004-4040 тусгай дугаарын утсаар болон www.ptd.ub.gov.mn, www.transport.ub.gov.mn цахим хуудсаар санал, мэдээлэл, гомдол, талархал гэсэн 4 төрлөөр тус тус хүлээн авч байна. Мөн оны эхнээс 11 дүгээр сарын 30-ны байдлаар Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой дуудлага мэдээллийг 7004-4040 тусгай дугаарын утсаар 72,061 дуудлага ирсэн байна.</p> <p>Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> -Авсан дуудлага – 63,181 буюу 87.2 хувь -Давхардсан дуудлага – 6,352 буюу 9.1 хувь -Аваагүй дуудлага – 2,524 буюу 3.7 хувь нь тус тус бүртгэгдсэн байна. Menteever.callpro.mn, www.ptd.ub.gov.mn, www.transport.ub.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирсэн санал, мэдээлэл, гомдол, талархал гэсэн 4 төрлөөр тус тус хүлээн авч байна. Нийт авсан 63,181 дуудлагыг 4 төрлөөр ангилж үзвэл: -Гомдол-594 буюу 0.89 хувь -Санал- 292 буюу 0.45 хувь -Талархал - 196 буюу 0.29 хувь -Мэдээлэл – 62,099 буюу 98.3 хувь тус тус эзэлж байна. | 7 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|---|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6.12. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Тайлангийн тоо | - | 1 | Ёс зүйн дэд хороо нь Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаартай тушаалаар байгуулагдаж, үйл ажиллагааны төлөвлөгөө 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор ажлаас чөлөөлөгдсөн 2 гишүүний оронд гишүүдийг нөхөн томилсон ба зөвлөлийн нарийн бичгийг томиллох газрын даргын тушаалын төслийг боловсруулж танилцуулахад бэлэн болсон. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. | 100 |
| 6.13. | Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | - | Сургалтын тоо | - | 2 | Ёс зүйн дэд хороо нь Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаартай тушаалаар байгуулагдаж, үйл ажиллагааны төлөвлөгөө 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулж, албан хаагчдад сургалт орохоор хуваарь гарган төлөвлөн ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2025 оны 09 дүгээр сарын 16, 10 дугаар сарын 07, 08, 17,-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад тус газрын хуулийн хэлтсийн холбогдох албан хаагчид болон бусад албан хаагчдыг хамруулсан. | 85 |
| 6.14. | Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана. | - | Мэдээллийн тоо | - | 2 | 2025 оны 05 дугаар сарын 28-наас 05 дугаар сарын 29-ний өдрүүдэд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны Нийслэл дэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Бусчилсэн хөгжил - Төрийн албаны манлайлал" сэдэвт сургалт хэлэлцүүлэгт нийт 12 албан хаагч хамрагдаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албаны | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|-------|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6.15. | "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвших. | - | Хувь | - | 100 | Тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль зэрэг хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2025 оны 09 дүгээр сарын 16, 10 дугаар сарын 07, 08, 17,-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад тус газрын 12 албан хаагчийг хамруулсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр зохион бүрдүүлэхэд анхаарах асуудал" сэдэвт сургалтад тус газрын 8 албан хаагчийг хамруулсан. Монгол хэлний тухай хуульд төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага 2025 оны нэгдүгээр сарын 01-нээс албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан албан хаагчдынхаа монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 2 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл нийт 30 цагийн сургалтыг "Хууль тогтоомж бодлого судалгааны төв" төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Амжилттай суралцсан 90 албан хаагчдаас 88 албан хаагчид Нийслэлийн Боловсролын газраас сертификат олгосон. 2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол бичгээр А4, А5 хэвлэмэл хуудсанд 2497 албан бичиг, 328 тушаалыг хэвлэмэл хуудсанд буулган ажилласан. Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II" Засгийн газрын 2022 оны | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|--|--|--------------------|------------------|--------------|-----------------|--|-------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | | 07 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэлтсийн албан хаагчид 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 02 дугаар сарын 14 хүртэл хугацаанд дунд шатны 12 удаагийн 30 цагийн сургалтад танхимаар хамрагдаж "Гэрчилгээ" авч өдөр тутмын албан бичиг хос бичгээр боловсруулан явуулж хэвшсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Монгол бичгийн цахим бичвэр сургалтад тус газраас давхардсан тоогоор нийт 30 албан хаагч хамрагдсан байна. | 96,6% |
| Дундаж хувь: / 100*59+90*3+85*9+80*1+70*2/ | | | | | | | |

Хянасан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч

(Х.Нямбаатар/



Тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга

Д.Отгонжаргал /

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2025 оны 12 дугаар сарын 04
Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-ийн үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

1.1. Тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус газраас 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийн дунджийг 96,6 хувиар тооцлоо. Үүнээс 85 хувь буюу түүнээс дээш “Үр дүнтэй” 71 арга хэмжээ байна. 60-84 хувь буюу “Үр дүн хүлээгдэж байгаа” 3 арга хэмжээ байна. “Үр дүн гараагүй” арга хэмжээ байхгүй байна.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Үр дүн хүлээгдэж байгаа” 3 арга хэмжээ байна. Үүнд:

1. “Бодлогын баримт бичгийн 1.4. “Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ” арга хэмжээ нь 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд төрийн өмчийн нийт 163 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 83 сургуульд сургуулийн хүүхдийн автобусны үйлчилгээг хүргэдэг. Энэ нь тус арга хэмжээний зорилтот түвшиний 70 хувьд хүрч байгаа үзүүлэлт юм.

2. “Бодлогын баримт бичгийн 2.1.3. “Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ” арга хэмжээ нь 80 хувьтай байгаа нь дулаан зогсоол барих сонгон шалгаруулах ажил буюу тендерийг 2 удаа зарласан боловч, техникийн шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй нэгж байгууллага шалгараагүйн улмаас 3 дахь удаагийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

3. “Бодлогын баримт бичгийн 3.5 “Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих” арга хэмжээн нь 2025 онд эхлүүлэхээр 1,0 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр “Наран босголт” ХХК шалгарсан. Барилгын ажлын явц 35 хувийн гүйцэтгэлтэй байна. 2026 оны орон нутгийн төсөвт үлдсэн 2,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгаж, гараашийн барилгын ажлыг дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

“Үр дүн гараагүй” арга хэмжээнүүд байхгүй байна. Тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээ нь 96,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтэс нэгжийн дарга нар, албан хаагчид, хамтран хэрэгжүүлэгч төслийн нэгж, ажлын хэсгийн гишүүдэд холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаанд нь чанартай тайлагнаж байхыг анхааруулах, цаашид авах арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:
ТАЙЛАН, МЭДЭЭ
ХАРИУЦСАН АЖИЛТАН



Д.ОТГОНЖАРГАЛ

З.ЦЭВЭЭНДОРЖ

Г.ЦОЛМОНГЭРЭЛ